

2022 оны зэргийн шалгалтын бүртгэл хийх тухай
(Зөвлөх зэрэг)

2022-01-28

1. Бүртгэлийг цахимаар буюу **Google Forms** ашиглан бүртгэл хийнэ. Иймд эмч бүр өөрийн **gmail** хаягтай байх шаардлагатай ба өөрийн gmail хаягаар орж бүртгүүлнэ.
2. Материалыг бэлнээр хүлээн авахгүй.
3. Бүртгэл 2022 оны 2 сарын 1-нээс 15-ны өдрийн 17 цаг 00 минут хооронд явагдана. (бүртгэлийн холбоосыг 2022-01-31-нд зарлана)
4. Холбогдох материалуудыг **сканердаж** хавсаргана. Үүнд:
 - 4.1. Иргэний үнэмлэхний хуулбар (зөвхөн нүүр тал)
 - 4.2. Мэргэшлийн дипломын хуулбар (резидент төгссөн диплом)
 - 4.3. Эмчлэх эрхийн лизензийн хуулбар
 - 4.4. Мэргэшлийн зэрэг өмнө нь хамгаалсан бол үнэмлэхний хуулбар
 - 4.5. 3*4 хэмжээний фото зураг (сүүлийн 6 сар доторх)
 - 4.6. НДД-ийн хуулбар (эхний зурагтай болон сүүлийн бичлэг бүхий хуудас)
5. Мэргэшлийн зэргийн шалгалтанд орохыг хүссэн хувийн өргөдөл (ЭМХТ-ийн цахим хуудсанд байгааг татаж авч бөглөнө)
6. Байгууллагын даргын баталгаажуулсан мэргэшлийн зэрэг горилогчийн бүрэн бөглөсөн маягт (ЭМХТ-ийн захирлын шийдвэрээр батлуулсан загвараар, ЭМХТ-ийн цахим хуудсанд байгааг татаж авч бөглөнө, сканердаж хавсаргана.)
7. Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтний тухайд харьяалах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас дэмжсэн тодорхойлолт (сканердаж хавсаргана)
8. Биелүүлсэн багц цаг. (2017-2019 оны жил тутмын 6 багц цагийн 2/3 нь эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр байх) Гэрчилгээнүүдийг сканердаж хавсаргана.
9. **“Зөвлөх” зэргийн тусгай шаардлагыг хангасныг баталгаажуулах баримт бичгүүд.** Үүнд:
 - 9.1. Эх барих эмэгтэйчүүдийн практикт хийгддэг бүх төрлийн мэс заслуудын техникийг эзэмшсэн байх (ажлын баталгаажсан тайлан, хавсаргана)

- 9.2. Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэл, эмэгтэйчүүдийн өвчин эмгэгээс сэргийлэх, эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээний мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх (ажлын баталгаажсан тайлан, хавсаргана)
 - 9.3. Байгууллага, тасаг нэгжийн эрхлэгч эсвэл зөвлөхөөр ажиллаж байгаа болон ажиллаж байсан туршлагатай байх (НД дэвтэр дээрх тушаалтай нүүрийг сканердаж хавсаргана)
 - 9.4. Үндэсний болон аймаг, дүүрэг, амаржих газарт мөрдөх оношилгоо, эмчилгээний удирдамж, зөвлөмж, ном, гарын авлага 3-аас доошгүйг боловсруулсан байх (ажлын баталгаажсан тайлан, хавсаргана)
 - 9.5. Үндэсний болон аймаг, дүүрэг, амаржих газрын түвшинд хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр, стратеги, төсөл, төлөвлөгөө, заавар, журам 3-аас доошгүйг санаачилсан, хамтран боловсруулсан байх (ажлын баталгаажсан тайлан, хавсаргана)
 - 9.6. Эзэмшсэн мэргэжлээрээ 4-өөс доошгүй судалгааны ажил хийж онол практикийн хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх (илтгэлийн хураангуйн хуулбар, сканердаж хавсаргана)
 - 9.7. Тухайн мэргэшлээрээ сургалт семинар, онол практикийн хурал, зөвлөгөөнийг удирдан зохион байгуулсан байх (сүүлийн 5 жилийн ажлын баталгаажсан тайлан, хавсаргана)
 - 9.8. Өөрийн мэргэжлийн чиглэлээр эмчилгээ оношилгооны шинэ технологи 4-өөс доошгүйг эзэмшсэн байх (тайлангаар баталгаажуулна)
 - 9.9. Шавилан сургалтаар 5 ба түүнээс дээш тооны мэргэшлийн эмчийг дагалдуулан сургаж үр дүнд хүргэсэн байх (ажлын баталгаажсан тайлан, хавсаргана)
 - 9.10. Салбарын хөгжил, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудалд хувь нэмэр оруулсан манлайлагч байх (тайлангаар баталгаажуулж хавсаргана)
10. МЭБЭЭНХ-ны татвар (сүүлийн 3 жилийг тушаасан баримт сканердаж хавсаргана)

МЭБЭЭНХ